

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр

№ 24/24

Улаанбаатар хот

Зээлээр эх үүсвэр татан төвлөрүүлэх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2, 80.4 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4, 9.6.23 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ГУЗ”)-ийн 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор Ариг банкнаас энэхүү тогтоолын хавсралт №1-д заасан нөхцөлийн хүрээнд зээл авахаар шийдвэрлэсүгэй.
2. Ариг банктай энэхүү тогтоолын хавсралт №1-д заасан нөхцөлийн дагуу Зээлийн болон Барьцааны гэрээ байгуулах, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
3. Ариг банктай байгуулсан Зээлийн болон Барьцааны гэрээний хэрэгжилт, зээл ашиглалт болон холбогдох бусад мэдээллийг Компанийн ГУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр

№ 24/25

Улаанбаатар хот

Зээлээр эх үүсвэр татан төвлөрүүлэх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2, 80.4 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4, 9.6.23 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор Голомт банкнаас энэхүү тогтоолын хавсралт №1-д заасан нөхцөлийн хүрээнд зээл авахаар шийдвэрлэсүгэй.
2. Голомт банктай энэхүү тогтоолын хавсралт №1-д заасан нөхцөлийн дагуу Зээлийн гэрээ байгуулах, гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
3. Голомт банктай байгуулсан Зээлийн гэрээний хэрэгжилт, зээл ашиглалт болон холбогдох бусад мэдээллийг Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

Ө.БОЛДБААТАР

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр

№ 24/26

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захиралд эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2, 80.4 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.22, 9.6.23 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн эх үүсвэрийг үр ашигтай удирдах зорилгоор “Фанд Ми Бирж” ХХК-ийн богино хугацаат санхүүжилтийн үйлчилгээнд зээлдэгч болон санхүүжилт олгох эрхтэйгээр оролцох эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
2. Компани нь “Фанд Ми Бирж” ХХК-ийн богино хугацаат санхүүжилтийн үйлчилгээнд оролцоходоо баримтлах ерөнхий нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан нөхцөлийн дагуу “Фанд Ми Бирж” ХХК-тай холбогдох гэрээ, хэлцэл байгуулах, гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр) д олгосугай.
4. “Фанд Ми Бирж” ХХК-ийн богино хугацаат санхүүжилтийн үйлчилгээг Компанийн эрх ашиг болон дотоод бодлогод нийцүүлэн оновчтой ашиглах, үр ашигтай түвшинд удирдан зохион байгуулж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг Компанийн ТУЗ-д тогтмол тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



О.БОЛДБААТАР